

## **БХИС-ИЙН БАГШ НАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР**

### **ШИФР: “БАГШ”**

#### **АГУУЛГА**

**Нэгдүгээр бүлэг. БХИС-ийн багшийн хөгжлийн өнөөгийн байдал, шинжилгээ, дүгнэлт**

1.1 БХИС-ийн өнөөгийн байдал, эрхэм зорилго, зорилтуудын хэрэгжилт

1.2 БХИС-ийн 2008-2011 оны “БАГШ” хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ

**Хоёрдугаар бүлэг. “БХИС-ийн багш” хөтөлбөрийн үндсэн зорилго, зорилтууд**

2.1. Алсын хараа, зорилго, үнэт зүйлс

2.2. Хөтөлбөрийн зорилго

2.3. Хөтөлбөрийн зорилтууд

2.4. Хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээ.

**Гуравдугаар бүлэг. “БХИС-ийн багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, шалгуур үзүүлэлт, удирдлага, хяналт-үнэлгээ ба санхүүгийн нөөц**

3.1. БХИС-ийн багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, шалгуур үзүүлэлт

3.2. “БХИС-ийн багш ” хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, хяналт, үнэлгээ

3.3. “БХИС-ийн багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн нөөц

## **Нэгдүгээр бүлэг: БХИС-ИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ШИНЖИЛГЭЭ, ДҮГНЭЛТ**

### **1.1 Өнөөгийн байдал, эрхэм зорилго, зорилтуудын хэрэгжилт**

БХИС-ийн “Багш” хөтөлбөрийн зорилго, зорилтын хэрэгжилт, явц байдал, хүрсэн үр дүнг “Дээд боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлт, дүгнэх аргачлал”, “Багш” хөтөлбөрт хяналт тавих заалтын дагуу хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийг жил, жилээр өсөлт, бууралтын байдал зэргийг харьцуулсан байдлаар гаргах аргачлалаар үнэлэв.

“Багш” хөтөлбөрийн зорилго, зорилтын хэрэгжилт, хүрсэн үр дүнг хөтөлбөрт заагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу сүүлийн 3 жилд БСШУЯ, БХЯ, ЗХЖШ болон бусад хөндлөнгийн байгууллагуудаас хийсэн шалгалт, аттестатчилалын дүн, үнэлгээтэй харьцуулан үзэж, дүн шинжилгээ хийлээ.

“БХИС-ийн багш нарын талаар баримтлах бодлого, эрх зүйн үндэслэлийг боловсронгуй болгох, тэдний мэдлэг, мэргэжлийн ур чадвар, хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлж, тэнхим бүрт БХИС-ийн онцлогт тохирсон чадварлаг профессор-багшийн баг бүрдүүлэхэд чиглүүлэх” зорилгын хүрээнд:

- БХИС-ийн багшийг хөгжүүлэх, мэргэжлийг дээшлүүлэх, ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэх;
- БХИС-д багш бэлтгэх, сонгон шалгаруулж авах журмыг боловсронгуй болгох;
- Цэргийн (офицер, ахлагч) багшийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах эрх зүйн орчинг тегэлдөржүүлэх;
- БХИС-ийн багшийн нийгмийн хамгааллыг сайжруулах болон ажиллаж амьдрах ая тухтай орчинг бүрдүүлэх дэс дараатай бодлого хэрэгжүүлэх зорилтуудыг дэвшүүлж, хэрэгжүүлэхээр 26 үндсэн арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд 2010 он гэхэд хөтөлбөрийн I шат дуусч, цаашид цэргийн сургуулийн онцлогт тохирсон профессорын багт шилжиж, олон улсын болон дотоодын шилдэг их сургуулиудын жишигт хүргэхээр тооцсон байна.

2008 оны “Багш” хөтөлбөрийг боловсруулах 3 үндэслэл гаргасаныг задлан шинжилж үзвэл тухайн үед үндсэн багш нарын 13 хувь нь эрдмийн зэрэг, цолтой байсан бол одоо 18 хувь болж өссөн боловч их сургуульд тавигдах шаардлагыг

хангахгүй хэвээр байна. Харин 2010 онд “Офицер багшийн албан тушаалд тавих шаардлага, шалгаруулж ажиллуулах журам” батлагдан гарснаас хойш офицер багшийн сонгон шалгаруулалт, томилгоонд тодорхой ахиц гарсан байна.

Түүнчлэн сургалтыг нийгэм, зэвсэгт хүчин, оюутны эрэлт хэрэгцээнд нийцүүлэн өндөр үр дүнтэй явуулах, сургалтын орчин нөхцөлийг сайжруулах ажил арга хэмжээ зохих хэмжээнд хэрэгжиж байна. Зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд нийт 26 арга хэмжээ төлөвлөснөөс 19 арга хэмжээ хэрэгжсэн буюу хэрэгжих шатандаа, 7 арга хэмжээ хэрэгжээгүй буюу хэрэгжих хугацаа болоогүй байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилт 71 хувийн явцтай болохыг харуулж байна.

“Багш” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн байдлыг авч үзэхэд зарим үзүүлэлт тухайлбал, багшийг сонгон шалгаруулах, сургах, бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоо үндсэндээ бүрдэх эхлэл тавигдаж, ном, туурвил, нээлт, шинэ мэдлэг бүтээсэн багш нарын тоо, улсын болон олон улсын эрдэм шинжилгээ судалгааны хөтөлбөр төсөлд хамрагдсан багшийн тоо, багш нарын ажлын хэрэгцээний компьютер, интернэт сүлжээний тоо, гадаадын нэр хүндтэй хэвлэл мэдээллийн хэрэгсэл (сонин, сэтгүүл, интернет сүлжээ гэх мэт)-д бүтээлээ байрлуулсан, нийтлүүлсэн багшийн тоо, дотоодын их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, төр, олон нийтийн байгууллагын хурал, зөвлөлгөөнд илтгэл тавьсан багшийн тоо нэмэгдэж, зорьсон үр дүндээ хүрчээ. \Хавсралт 1\

Хэдийгээр хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр багагүй амжилтад хүрсэн ч багшийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, тэднийг хөгжүүлэх, санхүүгийн дэмжлэгийг сайжруулах талаар хийгдвэл зохих ажлууд байсаар байна.

2008 оны байдлаар БХИС-д 812 төрлийн 1998,2 кредит цагийн хичээл заадаг 213 багш ажиллаж, багшлах бүрэлдэхүүний 30 хувь нь цэргийн академи, 21 хувь нь цэргийн дээд сургууль, 49 хувь нь иргэний их, дээд сургууль төгссөн, үндсэн багш нарын 7,0 хувь нь доктор (Ph.D, Sc.D), 76 хувь нь магистр, 17 хувь нь бакалаврын зэрэгтэй, 23 хувь нь эрдмийн цол (профессор, дэд профессор)-той, орон тооны багш нарын 21 хувь нь заах арга зүй эзэмших сургалтад хамрагдаагүй байсан бол 2011 оны эхний хагас жилийн байдлаар БХИС-д 3861 кредит цагийн хичээл заадаг 202 багш ажиллаж, багшлах бүрэлдэхүүний 35 хувь нь цэргийн академи, 30 хувь нь цэргийн дээд сургууль, 35 хувь нь иргэний их, дээд сургууль төгссөн, үндсэн багш нарын 11 хувь нь доктор (Ph.D, Sc.D), 81 хувь нь магистр, 8 хувь нь бакалаврын

зэрэгтэй, 27 хувь нь эрдмийн цол (профессор, дэд профессор)-той, орон тооны багш нарын 82 хувь нь заах арга зүй эзэмших сургалтад хамрагдаад байна.

Багш нарын албан хэрэгцээний компьютерууд 100 хувь интернэтэд холбогдсон нь тэдний ажиллах нөхцлийг дээшлүүсэн төдийгүй багш өөрийгөө хөгжүүлэх боломжийг дээшлүүсэн арга хэмжээ болжээ.

Багшийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сурч боловсрох орчинг бүрдүүлэх чиглэлээр хийгдсэн ажлууд нь цаашид багшлах туршлага бүхий боловсон хүчний байр суурийг зохих төвшинд бүрдүүлжээ.

БХИС-ийн эрдэм шинжилгээний ажлын зорилгыг цогц бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангуулах, багш судлаачдыг чадваржуулах, урамшуулал, хариуцлагын тогтолцоог сайжруулах замаар эрдэм шинжилгээний ажил хийх боломж орчинг бүрдүүлэхэд чиглүүлж ажилласнаар сүүлийн 2 жилд эрдмийн зэрэг, цолтоны тоо нэмэгдэж, 2010 онд үндсэн багш нараас 13 багш БХЯ, ЗХЖШ-ын захиалгат төсөлт ажилд оролцжээ.

2010-2011 оны хичээлийн жилд БХИС-ийн төв, тэнхимүүдийн хүрээнд нийт эрдэм шинжилгээний 31 хурал зохион байгуулагдаж, 177 багш буюу нийт багшийн 77 хувь илтгэл тавьж хэлэлцүүлсэн нь өмнөх сургуулийн жилтэй харьцуулахад илтгэл тавьсан багшийн эзлэх хувь 4,6 хувиар өссөн эерэг үзүүлэлтүүд харагдаж байна.

Сургуулиас багш нарын хөдөлмөрийг үнэлж урамшуулах, тэдний нийгмийн зарим асуудлыг шийдэхэд “Багш” хөтөлбөрийн хүрээнд сүүлийн 2 жилд 33 багшид нийт 255, 327,500 \хоёр зуун тавин таван сая гурван зуун хорин долоо таван зуу\ төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлжээ.

Түүнчлэн бие бүрэлдэхүүнийг байр, орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлж, 2010-2011 онд 55 хүнд Төрийн албан хаагчдын орон сууцны хөнгөлөлттэй зээлэнд хамруулж, квотын байраар, 12 хүнийг албан тушаалын байраар, 22 хүнийг сургуулийн байрлалд шинээр баригдсан байраар тус тус хангасан бөгөөд Төрийн бус байгууллагын хөтөлбөрт хамруулж 4 хүнд 5 ханатай гэр олгуулсан зэрэг нь багш, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн чухал арга хэмжээ болжээ.

**БХИС-ийн өнөөгийн дүр төрх, гадаад ба дотоод орчны**  
**/SWOT/ шинжилгээ**

<b>Давуу тал</b>	<b>Сул тал</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Дээд боловсролын бүх зэргийн сургалт, эрдэм шинжилгээний ажил болон цэргийн албыг зохион байгуулж явуулах удирдлагын тогтолцоотой.</li> <li>• Ажиллагсадын ажлын байрны хариуцлага, сахилгач байдал, ёс зүйн тогтолцоог бүрдүүлж чадсан.</li> <li>• Улсын төсвийн санхүүжилтээр 100 % санхүүждэг. Сургалтын ажил үйлчилгээний төлбөрийн нэмэлт эх үүсвэртэй.</li> <li>• Хөгжлийн алсын хараа, бодлого, стратеги, эрхэм зорилгоо оновчтой тодорхойлсон мастер төлөвлөгөөтэй.</li> <li>• Стандартын шаардлага хангасан хичээлийн байр, танхимуудтай, сургалт, судлагааны ажил, үйлчилгээнд ашиглагдаж буй лаборатори, төрөлжсөн анги, кабинетууд байгуулагдаж, сургалтын техник хэрэгслэл, компьютер, мэдээллийн хангамж сайжирч, ном сурах бичгийн тоо нэмэгдэж, электрон номын сангийн эхлэл тавигдсан.</li> <li>• Сургалт эрдэм шинжилгээ, судлагааны ажил эрхлэн явуулах тусгай бүтэцтэй, судалгаа шинжилгээний ажил удирдах, арга зүйн зөвлөгөө өгөх мэдлэг, чадвар бүхий эрдэмтэн судлаачтай, судалгааны ажлын багтай.</li> <li>• Анхан болон ахисан түвшиний хоёр шатны магадлан итгэмжлэгдсэн, нийгэмэнд хүлээн зөвшөөрөгдсөн их сургууль болж чадсан.</li> <li>• Дээд боловсрол олгох сургалтын магдлан итгэмжлэгдсэн хөтөлбөртэй.</li> <li>• Дээд боловсролын бүх зэргийн Доктор, магистр, бакалаврын боловсрол олгох сургалтын тогтолцоо, агуулга, стандарт технологи нь кредит цагт суурилсан шинэ арга зүй төлөвшиж, дээрх сургалтыг үр дүнтэй явуулах орчин бүрдэн төлөвшиж байна.</li> <li>• Сургалтын агуулга, технологийн шинэчлэл, орчин, эрдэм судлалын ажил, гадаад харилцаа, нийт хамт олны идэвх зүтгэлд тодорхой ахиц, чанарын сайжруулалт гарсан.</li> <li>• БХИС гадаад, дотоодын сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, олон нийттэй харилцах харилцаа өргөжсөн, сургуулийн талаарх мэдээллийн тоо өсч, агуулга, цар хүрээ өргөжиж байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Дээд боловсролын байгууллагын чанарын удирдлага, хяналт-шинжилгээ, өөрийн үнэлгээ төлөвшөөгүй, мэдээллийн орчин үеийн нэгдсэн систем бүрэн нэвтрээгүй, сургуулийн гадаад харилцаа хязгаарлагдмал.</li> <li>• Сургуулийн байр, танхимуудын сантехник, дулааны систем хуучирсан, халуун усны системгүй, сургалтын зориулалттай зарим тоног төхөөрөмж хуучирсан, оюутны дотуур байр, зочин профессор хүлээн авах буудал, амралтын газаргүй.</li> <li>• Сургалтын төлбөр, бусад нэмэгдэл орлогыг сургуулийн санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд ашиглах боломж хязгаарлагдмал, эрх зүйн орчин бүрдүүлээгүй.</li> <li>• Багшлах бүрэлдэхүүний бүтээлч санаачлага дутмаг, тэдний бичсэн сурах бичиг, ном цөөн, Улсын болон салбарын шинж чанартай судалгаа, төслийн ажилд оролцох оролцоо хангалттай бус.</li> <li>• Багшлах бүрэлдэхүүний сургалтын үйл явцад жигд бус ханддаг, тэдний төлөвшил, харилцааны соёл, суралцах арга барил харилцан адилгүй.</li> <li>• Ижил төстэй мэргэжилтэн бэлтгэдэг мэргэжлийн тэнхимүүдийн чиглэл, багш нарын ажлын байрны тодорхойлолт, шинэ бүтэцтэй уялдуулан ажлын байранд тавигдах шаардлага, гүйцэтгэх ажлын чиг үүрэг гүйцэд тодорхойлогдоогүй;</li> <li>• Эрдэм шинжилгээний ажлын мэдээллийн нэгдсэн сан бүрэн бүрэлдээгүй, мэдээлэл солилцоо дутмаг, уг ажил хийхэд зориулсан орчин үеийн төхөөрөмж бүхий судалгааны лаборатори дутагдалтай.</li> <li>• Сургуулийн нийгэмд үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор дотоод нөөц бололцоо, багш, эрдэмтэд, судлаачдын оюуны чадавхийг ашиглан Батлан хамгаалах салбар, төрийн болон нутгийн захиргааны байгууллагад үзүүлэх сургалтын болон бусад ажил үйлчилгээний тоо цөөн, агуулга хэлбэр явцуу байна.</li> </ul>
<b>Боломж</b>	<b>Бэрхшээл</b>
<ul style="list-style-type: none"> <li>• 2008-2010 онд хэрэгжүүлсэн “Багш хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үр дүнд түшиглэн багшлах боловсон хүчний бэлтгэх хөгжүүлэх “БХИС-ийн БАГШ хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Шинэ менежмент, инновацид суурилсан хөгжлийн мастер төлөвлөгөөгүй байгаа нь сургуулийн эрхэм зорилго, эрхэмлэн дээдлэх зүйлс, бодлого, алсын харааг</li> </ul>

<p>боломжтой.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Багшлах бүрэлдэхүүний манлайлах чадавхийг дээшлүүлэх, үйл ажиллагаандаа инноваци хийх, арга барилаа төгөлдөржүүлэх боломжтой.</li> <li>• Сургалт, эрдэм судлалын ажлын орчинд инноваци хийж, сургуулийн материаллаг баазыг хөгжүүлж, сургалт-судалгаа-үйлдвэрлэл-дадлагын ажлын технологийн баазыг боловсролын түвшин бүртэй уялдаатай шинэчилж, хүч чадлыг нэмэгдүүлэх боломжтой.</li> <li>• Сургуулийн төсвийг хэмнэх, нөөцийг зөв байршуулах, санхүүгийн хяналтын үр дүнтэй механизм бий болгож, урсгал зардлыг бууруулж, төсөвт зардлын өгөөжийг дээшлүүлэх замаар хүний амьдрах болон сургалтын орчинг сайжруулах боломжийг бүрдүүлэх.</li> <li>• Батлан хамгаалах салбарын хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжилтнийг мэргэшүүлэх, (online) зайны сургалтанд шинэ хэлбэр нэвтрүүлэх, сургалтын зарим хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлж өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх боломжтой.</li> <li>• Багш нарын 60 орчим хувь нь 35 хүртлэх насны залуу багш нар байгаа нь тасралтгүй суралцах, байнга хөгжих, мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх, тухайн чиглэлээр нарийн мэргэшиж богино хугацаанд эрдэмжих боломж бүрдүүлж байна.</li> <li>• Элсэгчдийн чанарт анхааран ажиллах, багш сургах орчин бүрдүүлж, сонсогч, оюутныг дэмжих, суралцагчийн сурах үйл ажиллагааг идэвхжүүлж, шинэ арга, технологи нэвтрүүлж бүтээлч болгох, сонсогч, оюутан, сурагчдын бие даах төв байгуулж тэдэнд үзүүлэх үйлчилгээний хүрээг өргөтгөх боломжтой.</li> <li>• Сүлжээний төхөөрөмжүүд болон серверүүдийг нэгдсэн удирдлага хяналттай болгох, электрон номын сангийн үйлчилгээг өргөтгөх, бэлтгэж буй мэргэжлийн чиглэл бүрээр хэвлэмэл бус материалын сантай болох боломжтой.</li> <li>• Доктор, магистрын сургалтыг эрдэм шинжилгээний ажилтай нягт уялдуулж их сургууль төвтэй шинжлэх ухааныг төлөвшүүлэх боломжтой.</li> <li>• Зарим мэргэжлээр эчнээ, (Online) зайн сургалт явуулах, Төрийн болон нутгийн захиргаа, бизнес, олон нийтийн байгууллагын захиалгат, зорилтод, модулийн, түр болон явуулын сургалт зохион байгуулах, сургууль, багш, судлаачдаас нийгэм, олон нийтэд үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх боломжтой.</li> </ul>	<p>оновчтой тодорхойлох боломжийг алдагдуулж, хөгжлийг сааруулж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Удирдлагын бүтцийн хөндлөн, босоо холбоо төдийлөн цэгцлэгдээгүй, чанарын удирдлагын тогтолцоо төдийлөн төлөвшөөгүй, мэдлэгийн болон цагийн менежмент сул нэвтэрсэн.</li> <li>• Сургалтын орчин, техник технологийн шинэчлэл удаашралтай, хичээлийн байр, танхимын ашиглалтын менежмент хангалтгүй, оюутны дотуур байргүй.</li> <li>• Сургуулийн хөгжлийн зорилготой уялдуулан төсөвлөгдсөн санхүүгийн хөрөнгө, нөөцийг төлөвлөх, хуримтлуулах, оновчтой хуваарилах менежмент учир дутагдалтай, бизнес сэтгэлгээ, маркетинг, маркетингийн судалгаа хөгжөөгүй, офицер, багш, судлаачид, ажилтнуудын дунд төсөвт дулдуйдсан бэлэнчилэх сэтгэхүй хүчтэй байна.</li> <li>• Доктор, магистрын мэргэжлийн хичээл заах багшийн хүртээмж тааруу, сургалтыг орчин үеийн шинэ арга, технологээр зохион байгуулах багш нарын мэдлэг чадвар сайтар төлөвшөөгүй, эрчимт аудио ведио сургалт зохион байгуулах орчин бүрдээгүй.</li> <li>• Зарим мэргэжлээр нарийн мэргэшсэн багш дутмаг, суралцагч хамт олон байх баримжаа төдийлөн хөгжөөгүй, ажлын байран дээрх сургалт тогтмолжоогүй.</li> <li>• Мэдээллийн нэгдсэн төв байхгүй, цогц үйлчилгээ үзүүлэх техник, тоног төхөөрөмжийн хангамж дутагдалтай, номын сангийн үйлчилгээнд дотоод сүлжээг ашиглах нөхцөл бүрдээгүй байна.</li> <li>• Эрдэм шинжилгээний ажлын төсөв, санхүүжилт хангалтгүй, судалгаа, туршилт явуулах орчин үеийн лаборатори, багаж тоног төхөөрөмж хангалттай бус байна.</li> <li>• Нийгэм, олон нийттэй харилцах тусгай хөтөлбөргүйгээс төр засаг, олон нийт, бизнесийн байгууллага, иргэдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх, мэргэжлийн зөвлөгөө өгөх шинэ чиглэл, хэлбэр хомс, олон нийтэд зөв ойлголт өгөх, дэмжигчид, хандивлагчийн сонирхол, санаачлагыг өрнүүлэх ажил дутагдалтай байна.</li> </ul>
--	--

2011 оны 7 дугаар сарын 25-ны байдлаар БХИС-ийн үйл ажиллагаатай уялдуулан “Багш” хөтөлбөрийг үнэлэхийн тулд “Дээд боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлт, дүгнэх аргачлал”-ын дагуу сургуулийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхэд 84,3 хувь буюу “Сайн” үнэлгээтэй байв. Энэ нь БХИС-ийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд “Багш” хөтөлбөрт ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлээгүй болохыг харуулж байна.\Хавсралт 2\

## **1.2 БХИС-ийн 2008-2011 оны “БАГШ” хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ**

БХИС-ийн захирлын 2011 оны 143 дугаар тушаалаар томилогдсон комиссын бүрэлдэхүүн БХИС-ийн тэнхим \төв\-ийн дарга, нийт багш нарын ажлыг үнэлж, ажлын байрны аттестатчилал явуулах ажлыг зохион байгуулж, дүгнэсэн байдлаас харахад уг ажилд хамрагдсан 19 тэнхимийн даргаас 4 тэнхимийн дарга буюу 21,1 % нь “D”-хангалтгүй үнэлгээтэй, 131 багшаас 22 нь буюу 16,7 % нь “D”-хангалтгүй үнэлгээтэй тус тус шалгагдсан байна.

2011 онд БХИС-ийн багш нарт аттестатчилал явуулсан комиссын дүгнэлтэд: “... багш нарыг бэлтгэх, мэргэжил, боловсролыг нь дээшлүүлэх хөгжүүлэх, магистрантур докторантурт суралцуулах, эрдэм шинжилгээ судалгааны арга зүй эзэмшүүлэх, гадаад хэлний мэдлэг олгох ажил зэрэг ажил нь цогц бодлогогүй, тэднийг заах аргын сургалтад хамруулах, эрдэм шинжилгээний бага хуралд оролцуулах төдийгөөр хязгаарлагдаж байгаад ч дүгнэлт хийх..., багш нарын өөрсдийн хариуцлага, ажил үүргээ ухамсарлах, өөрийгөө хөгжүүлэхэд анхаарах асуудал дутмаг байгаа...” зэрэг дутагдал, доголдол байгааг тэмдэглэсэн байна.

“Багш” хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх явцад БХИС-ийн багш нараас авсан 2 удаагийн санал асуулга, жил бүрийн ажлын тайлангууд, аттестатчлалын дүнд шинжилгээ хийж үзэхэд хөтөлбөрт тулгарч байгаа дараах зарим асуудалд анхаарах нь зүйтэй байна. Үүнд:

- Багш нарыг сонгон авах, ялангуяа цэргийн мэргэжилтэй багшийг сонгон шалгаруулж авах асуудал;
- Шинэ залуу багш нарыг ажлын байрандаа дадлагжихад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор эхний 2 жилийн хичээлийн цагийн ачааллыг багасгах;

- Тэргүүний багш нарын туршлагыг дэлгэрүүлэх, тэргүүний багш шалгаруулах асуудлыг олон нийтэд нээлттэйгээр 1-2 сарын хугацаанд явуулах;
- Багшид зориулсан сурган заах арга зүй, сурган хүмүүжүүлэх чиглэлээрх ном, гарын авлага, сонин сэтгүүлүүдийг тодорхой тоогоор худалдан авах;
- Сургалтын төлөвлөгөөг ойр ойрхон өөрчлөхгүй байх, 4-5 жилд нэг өөрчлөлт хийх;
- Нэг багшид оногдох хичээлийн ачааллыг багасгах \одоо 22-24 кр байгаа\;
- Үндсэн хичээлийг тэнхимийн дарга, эрдэмтэд профессорууд, бусад хичээл, дадлага, семинарыг бусад багш нар заадаг байх;
- Багш нарыг 3-5 жилийн зайтай гадаадын сургалтад хамруулдаг байх;
- Докторантур, магистрантурт \6 жил түүнээс дээш\ сурч байгаа багшид хариуцлага тооцдог байх;
- Энгийн багш нарт зохих нэмэгдэл олгодог байх;
- Багш нарын гадаад үзэмжид анхаарах;
- Аттестатчлалыг тодорхой үечлэлтэй тэнхим, тэнхимээр дараалалтай явуулдаг болох;
- Сургалтын материаллаг нөхцөлийг сайжруулах;
- Сургалтын бодлогыг нэгдсэн бодлогоор удирдах ажиллагааг чанаржуулах;
- Ном, сурах бичгийг хэвлүүлэх урамшуулалын системтэй болох \ном хэвлэх мөнгийг нь бэлнээр олгодог байх г.м\;
- Багшийг хөгжүүлэх сургалтад хамруулах, анги даасан багшид нэмэгдэл олгох;
- Бичиг хэргийн зардал олгох;
- Багш нарыг ажлын байран дээр сургах зэрэг асуудлууд орж байна;

Дээрх асуудлуудыг судалж үзэхэд ихэвчлэн залуу багш нар гадаадад явж мэргэжил дээшлүүлэх сонирхолтой байдаг бол ахмад багш нарын хувьд багш нарыг ажлын байранд нь сургах нь зүйтэй гэж үзэж байна. Нийт багш нарын насны харьцааг задлан шинжилж үзэхэд сүүлийн 3 жилд 22-32 насны залуу багш нарын



эзлэх хувь 18 орчим хувиар нэмэгдэж, 45 дээш насны ахмад багшийн тоо 6 хувиар буурчээ.

Энэ нь цаг үеэ дагасан үзүүлэлт боловч 32 хүртэлх насны багш нар нийт багш нарын 54 орчим хувийг эзлэж байгаа нь харьцангуй залуу багш нарт багшлах ажлын дадлага туршлага гүйцэд суугаагүй, тухайн мэргэжлээрээ судалгааны ажил дөнгөж хийж эхлэх үедээ байгаа болон цэргийн сургуулийн онцлогт дасан зохицох үйл явц нь дуусаагүй байх зэрэг онцлог байдаг байна.

Хөтөлбөрт тулгарч байгаа асуудлын нэг нь багшийн хөгжлийн асуудлыг нэгдсэн бодлогоор удирдах, сургуулийн нэгдсэн үнэлгээ, бүртгэлийн системийг төлөвшүүлж, сургуулийн инноваци, өөрийн үнэлгээний албанд төвлөрүүлэх, багшийн хөгжлийн асуудлаар жил бүр үнэлэлт дүгнэлт өгч байх нь зүйтэй байна.

Түүнчлэн сургуулийн инноваци, өөрийн үнэлгээний албаар “Багш” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг цэргийн сургуулийн онцлогт тохируулан шинээр сонгуулан авах, хөтөлбөрийн хэрэгжилтэд хагас жил тутамд явцын үнэлгээ хийдэг болох шаардлага бий болж байна.

Инноваци, өөрийн үнэлгээний албыг шинээр зохион байгуулсан нь БХИС-ийн үйл ажиллагааг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах, ажлын уялдаа холбоог сайжруулахад чухал алхам болжээ.

“Багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарсан хүндрэлийн нэг нь сургалтын материаллаг орчин дутагдалтай байгаа, ялангуяа багш нарт зориулсан ном, гарын авлага, сонин сэтгүүл дутагдалтай байгаа явдал юм. Сургуулийн төв номын санд ихэвчлэн сонсогч, оюутанд зориулсан мэргэжлийн ном, гарын авлага байдаг байна.

2010 онд сургуулийн төв номын сан хугацаа нь дууссан номнуудыг акталж, одоогоор 66 мянга гаруй номтой байна \2009 онд 95 мянган номтой байв\.

БХИС-ийн нэг онцлог болсон багш нарын ихэнх хувийг эзэлдэг цэргийн мэргэжлийн багш нарыг сонгон авах, тэднийг багш болгон төлөвшүүлэх асуудалд онцгой анхаарах нь зүйтэй болохыг хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал, багш нарын аттестатчиллын дүн харуулж байгаа юм.

Хөтөлбөрт заагдсан арга хэмжээнүүдийг шаталсан хэлбэрээр хүргэх нь оновчтой арга хэдий ч шатлал хоорондын ажлын уялдаа холбоо, үйлчилгээг хүргэх хүчин чадал, нэгж хийгээд боловсон хүчний чадавхийн асуудалд анхааран боловсронгуй болгох шаардлагатай байна.

Багш хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг сургуулийн удирдлага болон БХЯ, ЗХЖШ-ийн чиг үүрэгт хавсрага байдлаар даалгасан нь ажлын ачааллыг нэмэгдүүлсэн төдийгүй бие даасан хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад учир дутагдалтай байв.

“Багш” хөтөлбөрийн үндсэн зорилго нь багшийг хөгжүүлэх, төлөвшүүлэх асуудал бөгөөд БХИС-ийн зарим тэнхимүүдийн удирдлагын арга барилыг захиргааны удирдлагаас мэдлэгийн удирдлага, өөрчлөлт шинэчилэлийн удирдлагад чиглүүлэн өөрчлөх нь хүндрэл бэрхшээлээс гарах нэг үндсэн нөхцөл болно.

Хөтөлбөрт заагдсан арга хэмжээнүүдэд төсөв хөрөнгийн хэмжээ хангалттай байдаггүй нь үр дүнтэй үйл ажиллагаа явуулахад хүрэлцдэггүй бөгөөд хүндрэл бэрхшээлийн нэг гол шалтгаан болжээ.

“Багш” хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийхэд багш нарт тавигдаж буй өнөөгийн шаардлагыг хангахгүй байгаа дараах 3 гол нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл шалтгаалж байна. Үүнд:

- Багшийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ эрчимжээгүй;
- Багш нарын нийгмийн асуудлыг бүрэн шийдвэрлээгүй;
- Санхүү, хөрөнгө мөнгөний хуваарилалт бага байгаа нь нөлөөлж байна.

### **Хөтөлбөрийн үр дүн ба сургамж**

Хөтөлбөрийн хүрээнд багшийн хөгжлийг дэмжих орчин бүрдүүлэх, тэдний мэдлэг ур чадварыг дээшлүүлж, нийгмийн хамгааллын асуудлыг сайжруулахыг зорьж, судлаач багш нарыг бэлтгэх, профессорын багт шилжих зэрэг стратегийг баримтлан ажилласан байна. Багш хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнтэй холбоотой дараахи амжилт ололттой болон алдаа, сургамжтай зүйлсийг дурдаж болох юм.

*Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд биелэгдсэн байдал:*

- Судлаач багшийн эзлэх хувийн жин- 13,5 %-иар өссөн.
- Доктор багшийн тоо -17,2% өссөн.
- Магистр багшийн тоо -33% өссөн
- Боловсролын болон эрдмийн зэрэг цолтны тоо-12% буурсан.
- Гадаад, дотоодын докторантурт суралцагч багшийн тоо-36% өссөн
- Гадаад хэлтэй, түүний дотор англи хэлний багшийн тоо – тогтмол
- Залуу (32 хүртэлх насны ), дунд (40-50), ахмад багш нарын харьцаа - Залуу багш нарын эзлэх хувь \18%-иар\ өссөн

- Ном, туурвил, нээлт, шинэ мэдлэг бүтээсэн багш нарын тоо-21,6 % өссөн
- Зохиогчийн эрх, патент бүхий багшийн тоо-тогтмол
- Улсын болон олон улсын эрдэм шинжилгээ судалгааны хөтөлбөр төсөлд хамрагдсан багшийн тоо-33,3 % өссөн
- Сонсогчдын сурлагын үзүүлэлт \ голч дүн, үнэлгээний дундаж үзүүлэлт\ - Үнэлгээний дундаж үзүүлэлт- 4,4 хувиар өссөн
- БХИС-ийн төсөвт багшид (багшийн хөгжилд) зориулсан төсөв зардлын хэмжээ, жин-төсөвгүй
- Багшийн шинэ бүтээл, нээлт, технологийн шийдэл зэрэг инновацийн хүчин зүйлийг дэмжих, туслах зорилгод зарцуулсан хөрөнгийн хэмжээ-146 100 төгрөгөөр багассан
- Компьютер хангамж, интернет сүлжээг ашиглах боломж бололцоог илэрхийлсэн тоон үзүүлэлтүүд- Интернет холболт 44,2 %-иар өссөн
- Багш нарт зориулагдсан ном, мэдээллийн хангамжийн зүйлүүд-2010 онд Багш судлаачдад зориулсан 20 хүний суудалтай танхим ашиглалтад орсон
- БХИС-ийн төсөвт багш нарын ахуй амьдралд үзүүлэх дэмжлэг, тусламжийн хэмжээ, жин-төсөвт байхгүй
- БХЯ, ЗХЖШ, БХИС-иас багш нарт үзүүлсэн дэмжлэг, тусламжийн нэр төрөл- БХИС-иас 33 багшид 5 нэр төрлийн нийт 255, 3 сая төгрөгийн тусламж үзүүлсэн
- Орон сууцаар хангагдсан байдал, эзлэх хувь-6%-иар өссөн
- НҮБ-ын энхийг дэмжих болон олон улсын бусад ажиллагаанд оролцсон багшийн тоо-100 % өссөн
- Олон улсын хурал семинар, зөвлөгөөн, сургууль, дадлагад оролцсон багшийн тоо-23,5 % буурсан
- Дотоодын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, төр, олон нийтийн байгууллагын хурал, зөвлөлгөөнд илтгэл тавьсан багшийн тоо-28,1 % өссөн
- Гадаадын нэр хүндтэй хэвлэл мэдээллийн хэрэгсэл (сонин,сэтгүүл, интернет сүлжээ гэх мэт)-д бүтээлээ байрлуулсан, нийтлүүлсэн багшийн тоо-12 % өссөн
- Олон улсын ЭШБ, их дээд сургууль, коллежийн гишүүн, цол, зэрэг хүртсэн

## багшийн тоо-тогтмол

Дээрх 23 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн байдлаас үзэхэд 2 үзүүлэлт буурсан, 2 үзүүлэлт төсөв хөрөнгө байхгүйгээс хэрэгжээгүй, бусад 19 үзүүлэлт буюу бүх шалгуур үзүүлэлтийн 82,6 хувь нь 2008 оны төвшингөөс өссөн дүнтэй байна. Энэ нь багш хөтөлбөр зарим нэг тодорхой амжилтад хүрсэн ба хөтөлбөрт заагдсан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангах боломж байгаа болохыг харуулж байна.

Гэвч багш нарт шинэ мэдлэг боловсрол эзэмшүүлэх, багшийг хөгжүүлэх, тэдний нийгмийн хамгааллын асуудлаар хэрэгжүүлж буй Багш хөтөлбөрийг олон нийтэд танилцуулах, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад чиглүүлэн багш нарын бүтээлч идэвхийг өрнүүлэх, хөтөлбөрийн хүрсэн үр дүн, амжилт ололтыг сурталчилах, мэдээлэх ажиллагаа хангалтгүй байсан зэрэг сул талууд байсан гэж үзэж байна.

Жил бүрийн багш нарын баяр, оны аварга багш нарыг шалгаруулах үеэр тэргүүний багш нарыг олон нийтэд сурталчилах ажлыг тогтмол амжилттай зохион байгуулж ирсэн нь сайшаалтай бөгөөд цаашид улирал бүр Багш хөтөлбөрийг сурталчилах, багш нарын туршлага солилцох, шинэ мэдээлэл өгөх үр дүнтэй бүтээлч арга хэмжээнүүдийг олон нийтэд тэр дундаа байгууллага, хамт олны идэвхийг нэмэгдүүлэхэд чиглүүлэн хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байх болно.

БХИС-ийн бүрэлдэхүүн сургууль, тэнхимүүдийн удирдлага багш нарын бүрэлдэхүүнээс хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тодорхой бүрэлдэхүүнийг оролцуулах нь хөтөлбөрийн биелэлт үр дүнд эерэгээр нөлөөлөх болно.

Багш нарын нийгмийн хамгааллыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой хөрөнгө мөнгийг сургуулийн төсөвт суулгах, үе шаттайгаар нэмэгдүүлэх чиглэлээр идэвхи санаачилгатай ажиллах, 2010 оны боловсрол үндэсний хөтөлбөртэй багш хөтөлбөрийг уялдуулах шаардлагатай байна.

БХИС-ийн багшийг хөгжүүлэх, мэргэжлийг дээшлүүлэх, ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэх нөхцөл хангалттай бүрдээгүй, багшийн цагийн ачаалал их байдаг зэрэг нь зарим хүндрэлийг учруулж байна.

Нөгөө талаар хөтөлбөрийн санхүүжилт нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хангалттай хүрэлцэхгүй байгаа нь хөтөлбөрийн нэг сул тал болжээ.

Багш хөтөлбөрийн ололттой тал нь шалгуур үзүүлэлт 2008 оны төвшиншөөс өссөн ба хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, дутагдалтай сул талыг илрүүлсэнд оршиж байна.

Хөтөлбөрийн гол амжилт нь БХИС-д багш бэлтгэх, сонгон шалгаруулж авах журмыг боловсронгуй болгож, цэргийн (офицер, ахлагч) багшийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах эрх зүйн орчинг тегелдэржүүлж, БХИС-ийн багшийн нийгмийн хамгааллыг сайжруулах болон ажиллаж амьдрах ая тухтай орчинг бүрдүүлэх дэс дараатай бодлого хэрэгжүүлэх зэрэг зорилтын хүрээнд хийгдсэн ажил, арга хэмжээ зохих хэмжээнд хэрэгжсэн явдал гэж үзэж байна. Тухайлбал, БХИС-ийн хэмжээнд 100 гаруй багш, албан хаагчдын байр, орон сууцны асуудлыг шийдвэрлэсэн нь томоохон амжилт юм.

Цаашид цэргийн сургуулийн онцлогийг энгийн мэргэжлийн багш нарт ойлгуулах, цэргийн анги, байгууллагад ажиллаж байгаад багш болохоор ирж буй офицер, ахлагч нарыг багшийн заах арга зүй, сурах бичигтэй ажиллах арга зүй зэрэгт сурган дадлагажуулахын тулд цэргийн дээд сургуулийн багш нарыг бэлтгэдэг төвийг байгуулах шаардлага бий болоод байгаа нь багш нараас авсан удаа дараагийн санал асуулгын дүнгээс тодорхой харагдаж байна.

Шинээр боловсруулах хөтөлбөрийн арга хэмжээнүүдийг зорилго, зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд чиглүүлэх, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг илүү нарийн тодорхой сонгож авах нь зүйтэй байна. Ойрын ирээдүйд эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажилд багш нарыг өргөнөөр татан оролцуулах, ном бүтээл, шинэ мэдлэг бүтээхэд нь олгох дорвитой урамшууллын систем, механизмыг бий болгох хэрэгтэй юм.

Багш нарыг аттестатчлалд үр дүнтэй бэлтгэх бололцоо нөхцөлөөр хангах, өмнөх аттестатчлалд хангалтгүй дүн үзүүлсэн багш нарын мэдлэг, дадлагыг дээшлүүлэх, өөрийгөө хөгжүүлэх эрмэлзлэл зорилго, чиглэлтэй болгох асуудлыг шинээр боловсруулах хөтөлбөрт тусгах шаардлагатай.

БХИС-ийг тэргүүлэх зэргийн их сургууль болгоход багш нарын хөгжлийн асуудал голлох нөлөөтэй бөгөөд цаашид багш хөтөлбөрийг өргөжүүлж, уг хөтөлбөрийн бүтцэд багшийг төгөлдөршүүлэх асуудлаар тооцоо судалгаа сайтай дэд хөтөлбөр, төслүүдийг оруулж, сургууль бүрд 5 доошгүй дэд төсөл, дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр тусгах шаардлагатай байна.

Хөтөлбөрийн нэг сургамжтай тал нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ажиллагааг сайжруулах, явц байдлыг илтгэх, мэдээлэх ажиллагааг хариуцсан албан тушаалтанг сургууль, тэнхим бүрд томилж үүрэгжүүлэх нь үр дүнг дээшлүүлэх, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангахад чухал шаардлагатай байгаа явдал юм.

Батлан хамгаалахын их сургуулийн эрдэм судлал, сургалтын ажил үйлчилгээний нэгдмэл чанарыг хангаж, мэдлэгийн өргөн багтаамжтай технологи нэвтрүүлэх, шинэ мэдлэг бүтээх, инновацийн менежментийг нэвтрүүлэхэд чиглүүлэн багшийн хөгжлийг төгөлдөршүүлэх зэрэгт хөтөлбөрийн зорилго, зорилтыг чиглүүлэн хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор шинэчлэн боловсруулах нь зүйтэй байна.

Хөтөлбөрийн гол сургамж нь БХИС-ийн Багш хөтөлбөрийг удирдлагын баримт бичигтэй сайтар уялдуулж, санхүүгийн тооцоо, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө зэргийг үндэслэл сайтай хийх шаардлагатай болохыг харуулсанд оршиж байна гэж үзэж байна.

## ДҮГНЭЛТ

БХИС-ийн багш нарын өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор 2008 онд Батлан хамгаалахын Сайдын тушаалаар БХИС-ийн “Багш” хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлсэн нь цаг үеэ олсон арга хэмжээ байлаа.

Багш хөтөлбөрийг үнэлэхэд дараахь хүчин зүйлсийг харгалзаж үзэх хэрэгтэй.

Үүнд:

- Багш хөтөлбөрийн асуудал нь нийгэм, эдийн засгийн байдлаас хамааралтай;
- Хөтөлбөрөөр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны зарим үр дүн гарахад тодорхой хугацаа шаардлагатай;
- Хөтөлбөрийг мэргэжил арга зүйн хувьд удирдах, хэрэгжүүлэх байгуулагууд нь шинэчилэгдсэн бүтэц, зохион байгуулалтаар ажиллаад удаагүй байгаа

БХИС-ийн “Багш” хөтөлбөр үндсэндээ хэрэгжиж байгаа боловч зарим хүчин зүйлс \зохион байгуулалт, хүний нөөц, хөрөнгө санхүү, хувь хүний идэвхи чармайлт\ - ээс шалтгаалан өмнөө тавьсан зорилго, зорилтоо зохих төвшинд хангасан гэж үзэх нь учир дутагдалтай байна. Багш хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд өмнөө тавьсан зорилтуудаас: “БХИС-ийн багшийг хөгжүүлэх, мэргэжлийг дээшлүүлэх, ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэх” зорилтын хэрэгжилт төдийлөн хангалттай бус байгаа ч бусад зорилтууд нь биелсэн буюу биелэх бүрэн боломжтой байгаа нь хөтөлбөрийн давуу тал болж байна.

Хөтөлбөрийн үр дүнг, шалгуур үзүүлэлт бүрээр гаргасан дүнг үзэхэд хөтөлбөрийн эдийн засгийн болон хүний хүчин зүйлээс шалтгаалан 2008-2009 онуудад тохиолдсон эдийн засгийн хямралаас үүдэлтэйгээр зарим тодорхой ажлууд хийгдээгүй, багшийн хөгжлийн талаар тодорхой ажлууд төлөвлөсөн боловч энэ нь зарим талаар зохих үр дүн өгөхөөр хэрэгжээгүй байгаа нь 2011 онд явагдсан аттестатчилалын үр дүнгээс харагдаж байна.

SWOT шинжилгээнээс үзэхэд сургуулийн тэргүүлэх байр суурийг хангах багшлах бүрэлдэхүүний эрдэм шинжилгээ, сургалтын ажил үйлчилгээний чиглэлүүдийг оновчтой тодорхойлж, маркетингийн идэвхтэй бодлогыг хэрэгжүүлэх эхлэл тавигдаж байна. БХИС-ийн “Багш” хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн боловч зарим хүчин зүйлс \зохион байгуулалт, хүний нөөц, хөрөнгө санхүү, хувь хүний идэвхи

чармайлт\ -ээс шалтгаалан өмнөө тавьсан зорилго, зорилтоо зохих төвшинд хангасан гэж үзэх нь учир дутагдалтай байна.

Хөтөлбөрийн үйл ажиллагааг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах, ажлын уялдаа холбоог сайжруулах, зорилго, зорилтыг хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалт бий болсон хэдий ч дунд, доод шатанд мэргэжил, арга зүйн хувьд нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг нь хангалттай хэмжээнд хүрээгүй байна.

Хэдийгээр зарим нэг дутагдалтай тал байгаа ч хөтөлбөрийн чухал ач холбогдолтойг харгалзан үзэж, цаашид сайжруулан боловсруулж, багшийн хөгжлийн асуудлыг чанарын өндөр төвшинд гаргах асуудал чухлаар тавигдаж байна.

“Батлан хамгаалах салбарт шинжлэх ухаан, технологи, инновацийг 2021 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө”, “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”, “БХИС-ийг 2010-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө” батлагдан гарсан нь хөтөлбөрийг цаашид шинэчлэн хэрэгжүүлэх таатай нөхцөл болж байна.

“Багш” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд нь зарим эерэг өөрчлөлтүүдийг харуулж байгаа боловч сүүлийн 2 жилд явагдсан БСШУЯ, БХЯ, ЗХЖШ, БХИС зэрэг удирдлагын байгууллагуудаас явуулсан үзлэг шалгалт, аттестатчлалын дүнд шинжилгээ хийж үзэхэд хөтөлбөрийн хэрэгжилт, тавигдсан шалгуур үзүүлэлтийн төвшинг зарим талаар хангаагүйд дүгнэлт хийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгох хэрэгтэй.

Аттестатчилалын зарим дүнгээс харахад тус сургуулийн хөдөлгөгч гол хүч болох зарим тэнхимийн дарга, багш нарын мэдлэг боловсрол, ур чадвар, ажлын үзүүлэлт өнөөгийн тавигдаж буй шаардлагад хараахан хүрэхгүй байгаа нь “Багш” хөтөлбөрийн хэрэгжилтэд бүх шатны дарга, захирагч нар илүү анхаарал хандуулж ажиллах шаардлага гарч байгааг илтгэж байна.

“Багш” хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийхэд багш нарт тавигдаж буй өнөөгийн шаардалгыг хангахгүй байгаа явдалд дараах нөхцөл байдал, дутагдал, доголдлоос шалтгаалж байна гэж ажлын хэсгийн зүгээс үзлээ. Үүнд:

- Багш нарын мэргэжлийн ур чадвар, сурган заах арга зүйн арга барил, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх талаар дорвитой ажил хийгдээгүй;
- Ижил төстэй мэргэжилтэн бэлтгэдэг мэргэжлийн тэнхимүүдийн чиглэл, багш нарын ажлын байрны тодорхойлолт, шинэ бүтэцтэй уялдуулан ажлын



байранд тавигдах шаардлага, гүйцэтгэх ажлын чиг үүрэг гүйцэд тодорхойлогдоогүй;

- Багшийн хийж буй судалгааны ажлын явц удааширалтай, үр дүн гардаггүй, энэ чиглэлээр тодорхой ажлын чиглэл байхгүй;
- Эрдэм шинжилгээний илтгэл судалгааны ажил хийж олон улс, улс, салбарын хэмжээнд бусад их дээд сургуулиудын хэмжээнд хэлэлцүүлсэн томоохон ажил хийгдээгүй;
- Багш нарын бичиг баримт боловсруулах дадлага, чадварыг хөгжүүлэх тал дээр бага анхаарсан;
- Багш нарын гадаад хэлний мэдлэгийг хөгжүүлж , гадаад оронд мэргэжил дээшлүүсэн хувь хэмжээ хангалтгүй;
- БХИС-ийн төсөвт багшийг хөгжүүлэх чиглэлээр санхүү, хөрөнгөний асуудалд лах байгууллагуудын анхаарал дутсан;
- Багшийн шинэ бүтээл, нээлт, технологийн шийдэл, заах арга зүйгээ хөгжүүлэх санаачилга зэрэг инновацийн хүчин зүйлийг дэмжих, туслах зорилгод төсөвлөсөн хөрөнгийн хэмжээ бага байгаа;
- Багш нарт зориулагдсан ном, мэдээллийн хангамжийн зүйлүүд хүртээмж бага, зарим талаар учир дутагдалтай;
- БХИС-ийн төсөвт багш нарын ахуй амьдралд үзүүлэх дэмжлэг, тусламжийн хэмжээ, жин харьцангуй бага байгаа зэрэг орж байна.

Цаашид багш хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахын тулд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн үзэж, дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Багш хөтөлбөрийг олон нийтэд суртачилах мэдээлэх ажлыг эрчимжүүлэх;
- Багшийн хөгжил, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах төсөвтэй болох
- Цэргийн дээд сургуулийн багш бэлтгэх төвтэй болох асуудлыг судлан хэрэгжүүлэх
- Эрдэм шинжилгээний ажилд багш нарын олноор оролцуулах, ном бүтээл туурвисан багш нарт чиглэгдсэн үр дүнтэй урамшуулалын механизмыг бүрдүүлэх

- Багш хөтөлбөрт сургууль, тэнхимүүдийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх зорилгоор тэнхимийн дарга, багш нарын оролцоотойгоор дэд төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх
- Хөтөлбөрийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох
- Дараагийн аттестатчлалд багш нарыг бэлтгэх асуудлыг үе шаттайгаар хэрэгжихээр хөтөлбөрт оруулах
- Жил бүрийн эцэст багш хөтөлбөрийн үр дүнг нийтэд мэдээлж байх зэрэг орж байна.

“Багш” хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор агуулга, бүтэцийг шинэчлэн өөрчлөх зайлшгүй шаардлагатай гэдэг нь хөтөлбөрт хийсэн явцын үнэлгээ, дүн шинжилгээний үр дүнгээс тодорхой харагдаж байна.

Иймд Багш хөтөлбөрийг “БХИС-ийг 2010-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө” болон удирдлагын бусад баримт бичгүүдтэй уялдуулан шинэчлэн боловсруулах зайлшгүй шаардлагатай гэж дүгнэж байна.

## Хоёрдугаар бүлэг. “БХИС-ийн багш ” хөтөлбөрийн үндсэн зорилго, зорилтууд

### 2.1. Алсын хараа, зорилго, үнэт зүйлс

БХИС-ийн багш хөтөлбөр нь БХИС-ийг 2010-2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөөтэй нягт уяалдуулсан алсын хараа нь багшийн хөгжил, удирдлагын шинэ арга технолог, чанарт тулгуурласан багшийн ёс зүй, эрдэм судлалыг дээдэлсэн судлаач багшийг бий болох зорилгийг мөрдлөг болгож 2020 он гэхэд батлан хамгаалах салбарын боловсролыг хөгжүүлэх судалгаа шинжилгээний ажлын үндэслэлийг боловсруулах чадавхитай, судлаач багшийг бий болоход чиглэгдэнэ.

БХИС-ийн багш хөтөлбөр нь БХИС-ийн багшийг ирээдүйн шинэ дүр төрхөд шилжүүлэх алсын харааг хэрэгжүүлж, түүнд хүрэхэд шаардлагатай нөөц, арга хэрэгслэлийг багтаасан байна.

БХИС-ийн багшийн алсын харааг доорхи байдлаар томъёолж байна.

- Судлаач багшийг бий болгох
- Багшийн ажлын байрны стандартыг боловсруулан боловсон хүчний хөгжих нөхцлийг бүрдүүлэн, багшлах бүрэлдэхүүнд чанарын өөрчлөлт хийх
- Профессор багшийн хөдөлмөрийн үнэлгээ, цалин хөлс, урамшуулалыг ажлын бодит гүйцэтгэл, үр дүнтэй нягт уялдуулдаг болгох, тэдний орлогын эх үүсвэр, бодит орлогыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн болон ахуйн хөнгөлттэй үйлчилгээний хүрээг өргөтгөх,
- Профессор багшийн мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх, шинэ технологи нэвтрүүлэн, эрдэм судлал, сургалтын ажил үйлчилгээний мэдээлэл хангамжийг эрс нэмэгдүүлэх
- Профессор багшлах бүрэлдэхүүний ёс зүй, манлайллыг хөгжүүлж, идэвхжүүлэх багш судлаачид туршилт судалгааны ажил хийх таатай орчинг бүрдүүлэх,
- Гадаад харилцааг өргөжүүлж, үр нөлөөг нь дээшлүүлэх

### 2.2. Хөтөлбөрийн зорилго:

**БХИС-ийн багшийн хөгжил, удирдлагын, шинэ арга технологи, чанарт тулгуурласан багшийн ёс зүй, эрдэм судлалыг дээдэлсэн судлаач багшийг бий болоход чиглэгдэнэ.**

### **2.3. Хөтөлбөрийн зорилтууд:**

2.3.1.БХИС-ийн профессор багш нарын талаар баримтлах бодлого, тэдний мэдлэг, мэргэжлийн ур чадвар, хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх.

2.3.2. Профессор багш, эрдэм шинжилгээний ажилтнуудыг системтэй бэлтгэх, мэргэшүүлэх, эрдэмжүүлэх, удирдах ажилтнуудын мэдлэгийг сэлбэн шинэчлэх, хүн өөрийгөө хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх.

2.3.3.Цэргийн (офицер, ахлагч) багшийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах эрх зүйн орчинг төгөлдөржүүлэх.

2.3.4.БХИС-ийн профессор багшийн нийгмийн хамгааллыг сайжруулах болон ажиллаж амьдрах ая тухтай орчинг бүрдүүлэх дэс дараатай бодлого хэрэгжүүлэх.

### **2.4. Хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээ.**

**2.4.1. БХИС-ийн профессор багш нарын талаар баримтлах бодлого, тэдний мэдлэг, мэргэжлийн ур чадвар, хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх:**

2.4.1.1. Профессор Багш нэг бүртэй хөгжил дэвшлийн гэрээтэй ажиллах.

2.4.1.2. Сургууль, тэнхим бүр Багш хөтөлбөрийн зорилгыг үндэс болгосон багшийг хөгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллах.

2.4.1.3. Гадаад хэл (англи, орос, хятад, япон гэх мэт) сурах боломж олгох, интернет ашиглах боломжийг нэмэгдүүлэх.

2.4.1.4. Профессор багш нарыг мэдлэг боловсролоо дээшлүүлэх, доктор, магистрийн зэрэг хамгаалахаар суралцаж байгаа багшид бүтээлийн чөлөө олгох, ачааллыг нь хөнгөлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

2.4.1.5. Сургалтад шинэ арга технологи нэвтрүүлэх, шинэ мэдлэг, нээлт бүтээл туурвил гаргах, практикт нэвтрүүлэхийг бүх талаар урамшуулах, дэмжих, туслах арга механизмыг бүрдүүлэх, нөхцөл бололцоогоор хангах арга хэмжээг БХЯ, ЗХЖШ-тай хамтран хэрэгжүүлэх.

2.4.1.6. Боловсрол судлал, арга зүйн сургалт, семинарыг жил бүр зохион байгуулж, залуу (шинэ ) багш нарын арга зүйн чадвар, дадлагыг сайжруулах, шинээр багш болсон хүмүүсийг багшлах эрх олгох сургалтанд хамруулж байх.

2.4.1.7. Профессор багшийг мэргэжлийн дагуу дотоод, гадаадын их дээд сургууль, дамжаа, семинар, сургалтанд хамруулах, мэргэжлээ дээшлүүлэх, багш солилцох, танилцах дадлага хийлгэх, төрөл бүрийн төслийн багт ажилуулах арга хэмжээг дэс дараатай системтэй зохион байгуулах.

2.4.1.8. Профессор багшийг олон улсын төсөл, хөтөлбөр, тэтгэлэг, улсын болон батлан хамгаалахын салбарын хэмжээний эрдэм шинжилгээний ажлын хөтөлбөр, төсөлд оролцохыг хөхүүлэн дэмжих.

2.4.1.9. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлынхаа үр дүнгээр багшийн туурвисан бүтээл (ном, сурах бичиг, гарын авлага, шинэ бүтээл, оновчтой санал гэх мэт)-ийг хэвлэх (техник, технологийн шийдэл, загвар гаргах гэх мэт)-д санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам тогтоон хэрэгжүүлэх.

**2.4.2. Профессор багш, эрдэм шинжилгээний ажилтаныг бэлтгэх, мэргэшүүлэх, эрдэмжүүлэх, удирдах ажилтнуудын мэдлэгийг сэлбэн шинэчлэх, хүн өөрийгөө хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх:**

2.4.2.1. Өөрийн сургууль, дотоод ба гадаадын их, дээд сургуулиудаас оюутан (сонсогч) сонгон шалгаруулж, хөнгөлөлттэй нөхцөл, тусгай хөтөлбөрөөр багш бэлтгэх. (мэргэжилтэн бэлтгэдэг мэргэжлээр жил бүр 5 хүн).

2.4.2.2. Багшийг уралдаант шалгаруулалтаар сонгон авч хөгжлийн гэрээтэй ажиллуулах.

2.4.2.3. Мэргэжлийн өндөр ур чадвартай гадаад, дотоодын эрдэмтэн судлаач, багш, профессоруудыг урилгаар ажиллуулах.

2.4.2.4. Багш, шавийн барилдлагааг хөхүүлэн дэмжих, сургуульдаа олон шавь, эрдэмтэн багш бэлтгэж буй ахмад багшийг урамшуулдаг байх, цэргийн сургуулийн онцлогт тохирсон профессор багшийг ажиллуулах бэлтгэл хангах.

2.4.2.5. БХИС-д олон жил үр бүтээлтэй ажилласан багшийг тэтгэх, урамшуулах арга хэлбэрийн үр нөлөөг сайжруулах.

2.4.2.6. БХЭШХ-г түшиглэн багш, судлаачдыг бэлтгэх, давтан бэлтгэх тогтолцоо, арга хэлбэрийг бий болгох.

2.4.2.7. Сургуулийн удирдлагын үйл ажиллагаанд шинэ мэдлэг, арга технологи, мэдээлэлжүүлэлт, эрдэмжилтийг дэмжсэн инновацийн менежментийг нэвтрүүлэх.

**2.4.3. Цэргийн багшийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, эрх зүйн орчинг төгөлдөржүүлэх.**

2.4.3.1. Цэргийн анги, салбарт мэргэжлийнхээ дагуу дадлага хийж байх нөхцөл бүрдүүлэх.

2.4.3.2. Цэргийн багшийн цэргийн цол, зэрэглэлийг ахиулах хууль эрх зүйн зохицуулалтыг багшийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах зорилтод нийцүүлэн төгөлдөршүүлэх.

2.4.2.3. Цэргийн багшийн цэргийн тэтгэвэрт гарах насны дээд хязгаарыг шинэчлэн тогтоох нөхцөл боломжийг судлан шийдвэрлэх.

2.4.2.4. Ахлагчийн сургуулийг өөрийн чадварлаг багшлах бүрэлдэхүүнтэй болгох асуудлыг дэс дараатай хэрэгжүүлэх.

2.4.2.5. Өөрийн сургууль, академи төгсөгчдөөс багш шалгаруулж авах боломжийг нэмэгдүүлэх эрх зүйн үндэслэлийг бий болгох.

**2.4.4. Багш нарын нийгмийн хамгааллыг сайжруулах болон амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд туслах үйл ажиллагааг хэрэгжүүлэх:**

2.4.4.1. Багшийг газар эзэмших эрхээ хэрэгжүүлэх, банкны хөнгөлөлттэй зээл, лизингийн үйлчилгээ авч амьдрал ахуйгаа өөд татахад тухайн авч буй зээлийн 10 хүртэл хувийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо бий болгох.

2.4.4.2. БХИС-ийн байрлалыг сургалт, үйлчилгээний иж бүрэн хотхон болгох арга хэмжээ хэрэгжүүлэх.

2.4.4.3. БХЯ болон БХИС-ийн хамтарсан хөрөнгө оруулалтаар 40 айлын орон сууц барьж, сургууль өөрийн мэдлийн орон сууцтай болох.

2.4.4.4. Багш нарт урамшуулалт цалинг ажлын үр дүнгээр нь олох тогтолцоо бий болгох.

**Гуравдугаар бүлэг. “БХИС-ийн багш ” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, шалгуур үзүүлэлт, удирдлага, хяналт-үнэлгээ ба санхүүгийн нөөц**

**3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого үйл ажиллагааны чиглэл, шалгуур үзүүлэлт**

БХИС-ийн профессор багш нар нь; Монгол Улс, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний хөгжлийн хэтийн төлөвт нийцүүлэн, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, бүтээлч сэтгэлгээтэй, чадварлаг мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэж, мэдлэгийн түвшинг баталгаажуулагч байна.

**Зорилт 1. БХИС-ийн профессор багш нарын талаар баримтлах бодлого, тэдний мэдлэг, мэргэжлийн үр чадвар, хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх.**

- Профессор багшийн ажлыг дүгнэх, чансааг тогтоох, чадварлаг эрдэмтдэд түшиглэн багшийг бэлтгэх;
- Профессор багшийн судалгааны ажлыг дэмжих тэнхим, бүрэлдэхүүний сургуулийн төвлөрүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох ;
- Гадаад дотоодын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Багш нарын англи хэлний болон мэдээллийн технологийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг жил бүр, үе шаттайгаар хэрэгжүүлж байх;
- Профессор багшийн бүтээлийг хэвлэх (техник, технологийн шийдэл, загвар гаргах гэх мэт)-д санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- Багш нарыг гадаадад мэргэжил дээшлүүлэх, суралцах, туршлага судлах боломжоор хангах асуудлыг үе шаттайгаар, өргөн хүрээнд шийдвэрлэх;
- Ахмад настуудад тавих анхаарал халамж болон сэтгэл санааны дэмжлэгийг цаг тухайд нь дүрэм, журмын дагуу үзүүлж байх ;
- Багшлах бүрэлдэхүүнийг чанаржуулах;

*Шалгуур үзүүлэлтүүд нь:*

- Профессор багшийн ажлыг жил бүр дүгнэж, чансааг тогтоож нийтэд мэдээлсэн байх;
- Туршлагатай эрдэмтдэд түшиглэн жил бүр 10-аас доошгүй багшид судалгааны арга зүй эзэмшүүлэх;
- Бүрэлдэхүүний сургууль, тэнхимд профессор багшийг түшиглэн сургалт, эрдэм шинжилгээний ажлыг төвлөрүүлэх эрх зүйн 3-аас доошгүй баримт бичиг боловсруулж мөрдүүлэх;
- Гадаад, дотоодын их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөр жилд 2 оос доошгүйг хэрэжүүлсэн байх;
- Багш нарын англи хэлний 3-н шатны сургалтыг хичээлийн жилд 1 ээс доошгүй удаа зохион байгуулж, 20-оос доошгүй профессор багш нарыг хамруулсан байх;
- Мэдээллийн технологийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг жилд нэг удаа зохион байгуулж, 20 доошгүй багш нарыг хамруулсан байх;
- Хичээлийн жил тутамд 5-аас цөөнгүй багш докторын зэрэг хамгаалсан байх ба мэргэжилтэн бэлтгэж буй тэнхимийн багш нарын 10 хүртэл хувийг докторын зэрэгтэй болгох;
- Докторантур, магистрантурт хэт удаан \10 жил түүнээс дээш\ сурч байгаа багшид хариуцлага тооцдог байх;
- Хичээлийн жилд 8 хүртэл багш магистрын зэрэг хамгаалж, 2015 он гэхэд баклавар багшийн тоог цөөрүүлэх;
- Хичээлийн жил тутамд боловсролын болон эрдмийн зэрэг, цолтны тоог 8 –аас доошгүйгээр нэмэгдүүлэх;
- Жил бүр гадаад, дотоодын докторантурт 2-оос цөөнгүй багшийг суралцуулах;
- Гадаад хэлтэй, түүний дотор орос, англи хэлтэй багшийн тоог тэнхим бүрд 4-өөс цөөнгүйгээр нэмэгдүүлэх;
- Профессор багш нарын бүтээлүүдэд дэмжлэг үзүүлэх;



- Ахмад настнуудад тавих анхаарал халамж болон сэтгэл санааны дэмжлэгийг 2-оос доошгүй удаа үзүүлж байх;
- 2 жил тутам нэг удаа багшлах бүрэлдэхүүний аттестатчлалыг явуулаж байх;

**Зорилт 2. Профессор багш, эрдэм шинжилгээний ажилтнуудыг системтэй бэлтгэх, мэргэшүүлэх, эрдэмжүүлэх, удирдах ажилтнуудын мэдлэгийг сэлбэн шинэчлэх, хүн өөрийгөө хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх.**

- Профессор багшийг бэлтгэх давтан бэлтгэх болон багшийг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх;
- Гадаад, дотоодын мэргэжлийн чадварлаг эрдэмтэн судлаач, багш, профессоруудаас суралцах тогтолцоо бий болгох;
- Багш, шавийн барилдалгааг хөхүүлэн дэмжих;
- Профессор багшийг тэтгэх, урамшуулах арга хэлбэрийн үр нөлөөг сайжруулах, тэдний мэдлэг мэргэжлийг дээшлүүлж, ур чадварыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, семинар зоион байгуулаж явуулах, багшийг чадваржуулах, багшийн үнэлэмжийг дээшлүүлэхэд онцгой анхаарах;
- Багш нарыг сурган заах арга зүйн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх курс семинарт бүрэн хамруулах;
- Багшийн ёс зүйг хангах, оюутны хүмүүжил төлөвшилд зохистой нөлөөлөх талаар онцгой анхаарч арга хэмжээ авч байх;

*Шалгуур үзүүлэлтүүд нь:*

- Багшийг бэлтгэх сургалтыг жилд 2-оос доошгүй удаа зохин байгуулсан байх;
- Багшийг хөгжүүлэх, ажлын байранд нь мэргэшүүлэх сургалтыг хичээлийн жилд 2- оос доошгүй удаа зохион байгуулаж явуулаж, профессор багш ажлын байрандаа тогтвор сууршилтай ажиллаж буй байдлаар;
- Хичээлийн жилд 6-гаас доошгүй гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын уриж хамтарсан төсөл хөтөлбөр, сургалт, семинар зохион байгуулаж явуулсан байх;
- Профессор багш нарт тэтгэлэг, урамшуулах арга хэлбэрийн байдлаар дүрэм журмын дагуу зохин байгуулаж явуулсан үр дүнгээр;

- Багш нарын мэргэжлийг дээшлүүлж, ур чадварыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, семинарыг хичээлийн жилд 3-аас доошгүй удаа зохион байгуулаж явуулах;
- Багшийн ёс зүйн дүрэмийг хэрэгжүүлсэн үр дүнгээр тус тус илэрхийлэгдэнэ;

**Зорилт 3. Цэргийн (офицер, ахлагч) багшийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах эрх зүйн орчинг төгөлдөржүүлэх.**

- Цэргийн анги, салбарт мэргэжлийнхээ дагуу дадлага хийж байх нөхцөл бүрдүүлэх;
- Цэргийн багшийн цэргийн цол, зэрэглэлийг ахиулах хууль эрх зүйн зохицуулалтыг багшийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах зорилтод нийцүүлэн төгөлдөршүүлэх;
- Цэргийн багшийн цэргийн тэтгэвэрт гарах насны дээд хязгаарыг шинэчлэн тогтоох нөхцөл боломжийг судлан шийдвэрлэх;
- Ахлагчийн сургуулийг өөрийн чадварлаг багшлах бүрэлдэхүүнтэй болгох асуудлыг дэс дараатай хэрэгжүүлэх;
- Өөрийн сургууль, академи төгсөгчдөөс багш шалгаруулж авах боломжийг нэмэгдүүлэх эрх зүйн үндэслэлийг бий болгох;

*Үр дүн ба шалгуур үзүүлэлтүүд нь:*

- Цэргийн анги, салбарт мэргэжлийнхээ дагуу жилд 6-гаас доошгүй багш дадлага хийсэн байх;
- Боловсруулан гаргасан хууль эрх зүйн зохицуулалтыг баримтаар;
- Цэргийн багшийн цэргийн тэтгэвэрт гарах насны дээд хязгаарыг шинэчлэн тогтоох талаар хийсэн судалгааны ажил, хэрэгжүүлсэн арга хэмжээгээр;
- Өөрийн сургууль, академи төгсөгчдөөс 1-ээс доошгүй төгсөгчийг багшаар сонгон шалгаруулж авч, багшлах арга зүйд сургасан байх;

**Зорилт 4. Багш нарын нийгмийн хамгааллыг сайжруулах болон амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд туслах үйл ажиллагааг хэрэгжүүлэх:**

- Профессор багш, ажилтан, ажилчдын ажлын ачааллыг оновчтой тогтоох болон ажлын үр дүнг бодитой үнэлэх замаар цалин хөлсийг өсгөж, үндсэн цалинг жил бүр инфляцийн төвшнээс багагүй хувиар нэмэгдүүлэх;
- Профессор багш нарийн чансааг тогтоох журмыг тэдний идэвхи санаачлагыг өрнүүлэх чиглэлээр боловсронгуй болгох;

- Ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээг албан тушаалын зэрэглэл, шагнал, урамшуулалтай нягт уялдуулах чиглэлээр аттестатчиллын тогтолцоог боловсронгуй болгох;
- Профессор багш, ажилтнуудын ажиллах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, компьютер техник хэрэгслийн хангамжийг сайжруулах;
- Нийт багш, ажиллагчдын хөдөлмөрийн үр дүн, ажлын гүйцэтгэлтэй уялдуулан зөв үнэлгээ явуулж байх “Ажлын үр дүн ба урамшуулал, хариуцлагын нэгдсэн систем” боловсруулан мөрдөж ажиллах;
- Нийт багш, ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, ялангуяа багш нарын орон сууцны хангамжийг сайжруулах асуудлыг төр, засгийн бодлоготой уялдуулан орон сууцны хөтөлбөрт хамруулах асуудлыг бодит ажил болгон хэрэгжүүлэх;
- Багш, ажиллагчдад нийгмийн халамж, үйлчилгээг цаг тухай бүр хүргэж байх;

*Үр дүн ба шалгуур үзүүлэлтүүд нь:*

- Профессор багш нарын цагийн ачааллыг оновчтой тогтоох;
- Ажлын үр дүнг бодитой үнэлэх замаар цалин хөлсийг өсгөж, үндсэн цалинг жил бүр инфляцийн төвшнээс багагүй хувиар нэмэгдүүлэх;
- Профессор багш нарийн чансааг тогтоох, тэдний идэвхи санаачлагыг өрнүүлэх чигэлсэн ажлыг хичээлийн жилд 4-өөс доошгүй удаа зохион байгуулаж явуулсан байх;
- Багшийг газар эзэмших эрхээ хэрэгжүүлэх, банкны хөнгөлөлттэй зээл, лизингийн үйлчилгээ авч амьдрал ахуйгаа өөд татахад тухайн авч буй зээлийн 10 хүртэл хувийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо бий болгох;
- БХЯ болон БХИС-ийн хамтарсан хөрөнгө оруулалтаар 40 айлын орон сууц барьж, сургууль өөрийн мэдлийн орон сууцтай болох;
- Багш нарт урамшуулалт цалинг ажлын үр дүнгээр нь олох тогтолцоо бий болгох;

### **3.2. “БХИС-ийн багш ” хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, хяналт-үнэлгээ**

БХИС-ийн багш хөтөлбөрийн үндсэн зорилго чиглэлийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг тэргүүлэх болон хамтран хэрэгжүүлэх газар, хэлтэс, нэгжүүдэд

оногдуулан, цаашид доороос гарах тулгамдсан, шийдвэрлэх шаардлагатай асуудлыг шийдвэр гаргах төвшиний байгуулагуудын шийдвэрт тусгаж байхын тулд төлөвлөгөөг боловсруулах үе шатанд ашигласан зөвлөлдөх үйл явцыг үргэлжлүүлэх нь зүйтэй. Үүний тулд бүтэц, үйл ажиллагааны уялдаа, холбоог бэхжүүлэн хөгжүүлэх, ингэснээр анхан шатны төвшинд ажиллаж буй ажилтнууд шийдвэр гаргах үйл явцад тогтмол, системтэй оролцож салбарын хэмжээний тэргүүлэх асуудалд нөлөөлөх боломжийг бий болгох юм.

БХИС-ийн багш хөтөлбөрийн үндсэн зорилго зорилтын хэрэгжилтийг бүх төвшиний нэгжийн удирдлага хариуцах ёстой учраас тэдний удирдлагын чадавхи, манлайллыг бэхжүүлэхэд онцгой анхаарах ёстой.

### **3.2.1 “БХИС-ийн багш 2020 он” хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, хяналт, үнэлгээ**

Батлан хамгаалах яам, ЗХЖШ, Сургуулийн удирдлага багш хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлыг үнэлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах, мэдээллийн өгөгдлийн бааз байгуулах, бодлогын дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, түүний гүйцэтгэлийн талаар тайлан мэдээ гаргаж, Батлан хамгаалах яам, хандивлагч, гүйцэтгэгч байгууллага, сонирхогч талууд, олон нийтэд мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Багш хөтөлбөрийн хэрэгжүүлж байгаа зорилтод хөтөлбөр, төслийн ажлын явц, бодит гүйцэтгэл, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг тухайн хөтөлбөр, төслийн зорилго, зорилт, арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаанаас хамааран тухайн үед нь тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу гүйцэтгэнэ.

Багш хөтөлбөрийн хэрэгжүүлэх үе шат бүрийн сүүлийн жилд тухайн үе шатанд тавьсан зорилт, хэрэгжүүлсэн арга хэмжээг бүхэлд нь хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

Батлан хамгаалах яам тус сургуулийн багш хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, бодит гүйцэтгэл, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээний дүн, цаашид авах арга хэмжээг жил бүрийн 2 дугаар сард тодорхойлж байна.

Ингэхдээ БХИС-ийн багш хөтөлбөрийн тусгагдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх хугацаа, хүрэх эцсийн үр дүн, хувиарлагдсан төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан эсэхэд түлхүү анхаар.

## **“БХИС-ийн багш ” хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн нөөц ба эрсдэл**

Батлан Хамгаалах Их Сургуулийн үйл ажиллагааны санхүүжилтийн өнөөгийн хувь хэмжээг хэвээр хадгална гэж үзвэл Батлан хамгаалах салбарт баталж өгсөн төсвийн 5 хувийг эзлэж байна. Харин цаашдаа Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх 12 жилийн хугацаанд дээрх хувь хэмжээ 7-9 хувь болж өөрчлөгдөнө. Эндээс харах юм бол БХИС-ийн санхүүжилтийг эхний хувь хэмжээгээр байлгах юм бол хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжгүй болох юм. Иймд энэ хувилбараас татгалзаж боломжит хувилбарыг сонгох нь зөв юм.

### **3.3. Хөтөлбөрийн санхүүжилт.**

- Төсвийн хөрөнгөөр (БХЯ, ЗХЖШ-ын хөрөнгө оруулалтаар) нийт зардлын 40%.
- БХИС-ийн үндсэн үйл ажиллагааны ажиллагааны орлогоос (хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын 10%).
- Иргэд, байгууллагын хандив тусламжийн хөрөнгө. (10%).
- Гадаад тусламж, дэмжлэгийн зүйл (15%).
- Бусад эх үүсвэр.(25%).

#### **3.3.1. Хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүн**

- Багшийн мэргэжлийн бэлтгэл, заах арга зүй, ур чадвар дээшилж, сургалтын чанарт ахиц гарна.
- Багш бүр судлаач болж, багш оюутан /сонсогч/-ы эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн дээшилнэ.
- Багшийн орлого нэмэгдэж, амьжиргааны түвшин ахина.
- Багшийн нэр хүнд, бүтээлч идэвх санаачлага дээшилнэ.

#### **3.3.2. Ерөнхий үр дүн.**

- Багш нарын талаар баримтлах хүний нөөцийн бодлогын эрх зүйн үндэслэл сайжирна.
- Багш нарын дотор эрдмийн зэрэгтэй багш нарын эзлэх хувь дээшилж их сургуульд тавигдаж буй стандарт шаардлагыг бүрэн хангана.
- Багш нарыг төрөл бүрийн мэдээллээр хангагдах ажил боловсронгуй болж тогтмолжиж компьютер, интернетээр бүрэн хангагдана.

- Магистр, докторантурын сургалт боловсронгуй болж доктор, магистрын зэрэгтэй багш нарын эзлэх хувь их сургуульд тавигдах жишиг үзүүлэлтэд хүрнэ.
- Багш нарын хөгжлийн ажиллах орчин бүрдэж Монгол улсын шилдэг их сургуулиудын түвшинд хүрнэ.

### **3.3.3. Зарим тодорхой үр дүн.**

- Багшийн загвар стандартыг шинэчлэн боловсруулж дуусгана. (2011 онд).
- БХИС-ийн магистр, доктор багш нарын тоогоороо их сургуульд тавигддаг шалгуур үзүүлэлтийг бүрэн хангана. (2013 онд).
- Сургалтын орчин, компьютер, интернет үйлчилгээгээр бүрэн хангагдана. (2012 онд багш, судлаач бүр интернет сүлжээнд холбогдсон компьютертэй болно).
- БХИС-ийн бүтэц, зохион байгуулалтанд өөрчлөлт хийж сургалт, эрдэм шинжилгээ эрхэмлэсэн бүтцэд шилжиж, байнгын бүрэлдэхүүний дотор багш нарын эзлэх хувь 60 хувьд хүргэнэ. (2012 онд)
- Багш нарын нийгмийн хамгаалал дээшилж тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэнэ. (2011-2020 онд)

### **3.3.4. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих тухайд,**

- БХИС болон бүрэлдэхүүний сургуулиудын үйл ажиллагаанд жил бүр судалгаа шинжилгээ хийх замаар хяналт тавьж, үр дүнг тооцож, эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэнэ.
- БХИС-ийн сургалт, арга зүйн удирдамж, баримт бичгүүдийг Боловсролын тухай шинэ хуулиуд, МУ-д шинжлэх ухаан технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийн заалт, шаардлагуудад нийцүүлэн шинэчлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцно.
- "Багш" хөтөлбөрийн хэрэгжилтийг шалган тусалж, мэдээлж байдаг хөндлөнгийн хяналтын бүлэг ажиллуулж ажлын явцыг багш, сургуулийн удирдлагад жил бүр мэдээлнэ.
- "Багш" хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийг доорхи байдлаар тогтоож жил бүр биелэлтийг нь тооцож гаргана.

*Сургалтын бодлого, зохицуулалтын алба*